

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



НИЙЦЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: “ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН”

АУДИТЫН КОД: ДУА-2025/21-10-ШТА-НА

Дундговь аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор
Р.Мөнхтогтох Утас: 70592439
Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225
Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Ихбаяр
Утас: 7059-3113

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

График товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн хэрэгжилт/ Хувиар/	8
График 2	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийн ангилал /сая төгрөгөөр/	8

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4-12 дугаар зүйлийн зөрчлийн ангилал	4
Хүснэгт 2	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4 заалтын хэрэгжилт /Тоогоор/	5
Хүснэгт 3	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасныг зөрчсөн асуудал	7
Хүснэгт 4	Зохион байгуулсан худалдан авах ажиллагаа, хэмнэлт /сая төгрөгөөр/	9
Хүснэгт 5	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасныг зөрчсөн асуудал	10
Хүснэгт 6	Цахим худалдан авалттай холбоотой зөрчил	10
Хүснэгт 7	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	12

“ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН”-НД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Огноо: 2025.05.19

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ДУА-2025/21-10-ШТА-НА	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Аймаг сумын ИТХ, ЗД, ЗДТГ харьяа хэлтэс
Аудитын нэр:	“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт үр дүн”		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	1-р нэгж

Хоёр. Аудитын үр дүн:

2.1 Аудитын зорилго, хамрах хүрээ:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган, илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдэлийг бууруулах талаар санал, зөвлөмж боловсруулан аудитын дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг заасан хугацаанд нь арилгуулж, хууль, журмын хэрэгжилтийг хангуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан эсэх;
Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан эсэх;
Засгийн газар болон төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан эсэх;

Аудитыг Дундговь аймгийн ТЕЗ-ын харьяа болон улсын төсвийн байгууллагуудын 2022, 2023, 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлантай уялдуулан санхүүгийн үйл ажиллагааг түүвэрт хамруулж холбогдох баримт материалын хүрээнд хийж гүйцэтгэлээ.

2.2 Бүлэг А. Аудитын дүн:

А. Гол асуулт / аудитын дэд зорилт 1: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан уу?

Хариулт: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зарим байгууллагууд бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.1 ЗАРИМ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД ХАНГАМЖ, ЗАРИМ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯЗГААРЛАЛТ ХОЛБООТОЙ ЗААЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн 2 дугаар бүлэг буюу 5-12 дугаар зүйлд хангамж, зарим үйл ажиллагаанд тавих хязгаарлалттай холбоотой асуудал тусгагдсан байна.

Дундговь аймгийн төсөв захирагчдын 2022-2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар хуулийн 5-12 дугаар зүйлийн заалтуудтай холбоотой нийт 224.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 9.0 сая төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 81.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлэн, 134.0 сая төгрөгийн зөрчлийг тухайн шатны төсөвт буцаан төвлөрүүлэхээр санхүүгийн тайланд авлагаар тайлагнуулж залруулсан байна. *Хүснэгт №1*

Хүснэгт №1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4-12 дугаар зүйлийн зөрчлийн ангилал /2022-2024 он/ /сая.төг/

№	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалт	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТХТХ 4.2.6. ¹	8	134.0	1	6.0	4	61.0	13	201.0
2	ТХТХ 4.2.7. ²					1		1	-
3	ТХТХ 6.3. ³			1	0.1	1	2.6	2	2.7
4	ТХТХ 8.1. ⁴			1	1.8	5	9.1	6	10.9
5	ТХТХ 9.2. ⁵					1		1	-
6	ТХТХ 10.1. ⁶					1	8.4	1	8.4
7	ТХТХ 12.1.1. ⁷			1	0.5			1	0.5
8	ТХТХ 12.1.3. ⁸			1	0.6			1	0.6
Нийт дүн		8	134.0	5	9.0	14	81.1	26	224.1

Эх сурвалж: Дундговь аймаг дахь ТАГ-ын статистик мэдээ

Хуулийн 4-12 дугаар зүйлд заасан “хангамж, зарим үйл ажиллагаанд тавих хязгаарлалт”-тай холбоотой асуудлыг агуулгаар нь авч үзвэл :

1.1 Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим - 4 дүгээр зүйл



2022 онд Дундговь аймаг үүсэн байгуулагдсаны 80 жилийн ой тохиож, ойн арга хэмжээний хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.6-д заасныг зөрчиж, 8 сумын ТТЗ 195.0 сая төгрөгийг үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй арга хэмжээнд зарцуулсан зөрчил илэрснээс 134.0 сая төгрөгийн зөрчлийг тухайн шатны

¹ үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх;

² аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх;

³ Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн автотээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно.

⁴ Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.

⁵ Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ.

⁶ Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

⁷ үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал;

⁸ хэвлэлийн захиалгын төлбөр;

төсөвт буцаан төвлөрүүлэхээр санхүүгийн тайланд авлагаар тайлагнуулж залруулан, 61.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг нь бүрэн хангуулсан. Төсвийг үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй арга хэмжээнд зарцуулсан санхүүжилттэй холбоотой **134.0** сая төгрөгийн авлагыг сумдын ТТЗ -нар бүрэн барагдуулж ажилласан байна.

1.2 Тэргүүн дэд, дэд, орлогч дарга - 5 дугаар зүйл



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу байгууллагын бүтэц, орон тооны тушаалд тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн орон тоо байгаа эсэхийг тулган шалгахад зөрчил илрээгүй. Аймаг, сумдын Засаг дарга 1-ээс илүү орлогч дарга ажиллуулаагүй байна.

Дундговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор дэд даргыг Дундговь аймгийн ХХҮГ-ын даргын 2022 оны Б/63 дугаар тушаалаар үүрэгт ажлаас чөлөөлж, энэ хуулийн хүрээнд дэд даргын орон тоог хасаж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

1.3 Тээврийн хэрэгсэл- 6 дугаар зүйл



Хуулийн 6 дугаар зүйлд зааснаар авто машин ашиглах эрхгүй албан тушаалтан албаны машин хэрэглэж, 2.7 сая төгрөгийн шатахууны зардал гаргаж хяналтгүй зарцуулсан зөрчлөөс 0.1 сая төгрөгийн орон нутгийн орлогод буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоож, 2.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг 2022 онд хүргүүлсэн. Тухайлбал:

- Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга нь аймаг дотор албан тушаалын суудлын автомашин ашиглаж Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хориглосон заалтыг зөрчиж, тээвэр шатахууны зардлыг хяналтгүй, хэмнэлтгүй зарцуулсан.

Нийцлийн аудитын явцад хийсэн шалгалтаар албан тушаалын суудлын авто машин ашиглах эрхгүй 2 албан тушаалтан албан тушаалын суудлын авто машин ашигласан байсан зөрчлийг илрүүлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын даргад хүргүүллээ.

2022 онд аймгийн Орон нутгийн өмчийн газраас ЗГ-ын 2022 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолын дагуу суудлын авто машин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй судалгааг аймгийн Засаг даргад танилцуулж, нийт 64 тээврийн хэрэгслийг актлах, дуудлага худалдаагаар худалдахаар холбогдох байгууллагуудад журмын дагуу материал бүрдүүлэн ирүүлэх албан бичиг хүргүүлсэн байна. Дээрх тогтоолыг орон нутагт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаагаас 24 автомашиныг татан төвлөрүүлж аймгийн ИТХ-ын 2023 оны 19 дүгээр тогтоолоор 24 машиныг дуудлага худалдаагаар борлуулахаар шийдвэрлэж 16 авто машиныг борлуулан **206.4** сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

ТЕЗ-аас 2023 онд Орон нутгийн өмчид бүртгэлтэй, ашиглагдаж байгаа бүх төрлийн авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солиулах арга хэмжээг аймгийн хэмжээнд авч хэрэгжүүлсэн байна. Гэвч 2024 жилийн эцсийн байдлаар Орон нутгийн өмчит байгууллагад бүртгэлтэй **73** байгууллагын **403** авто тээврийн хэрэгслийн 54.8 хувь буюу **221** нь бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаартай байна. Бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй **43** байгууллагын **182** авто тээврийн хэрэгслийн шалтгааныг судлахад 10 байгууллагын 54 авто машин эвдрэлтэй, актлах шийдвэр гарсан, санал хүргүүлэх гэх мэт шалтгаантай бөгөөд 43 байгууллагын **128** тээврийн хэрэгсэл гаалийн бичиг байхгүй, зөрүүтэй, нэр шилжээгүй, тодорхой шалтгаангүй байна.

Хүснэгт №2 Хуулийн 6.4 заалтын хэрэгжилт /Тоогоор/

Цэнхэр дугаар авсан		Цэнхэр дугаар аваагүй	
Байгууллага	Тээврийн хэрэгсэл	Байгууллага	Тээврийн хэрэгсэл
30	221	43	182
Цэнхэр дугаар аваагүй шалтгаан			

Хүндэтгэн үзэх шалтгаантай	Хүндэтгэн үзэх шалтгаангүй
54	128

Иймд байгууллагын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа боловч шалтгаангүйгээр тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй авто тээврийн хэрэгслийн

дугаарыг шинэчилж хуулийн хэрэгжилтийг хангуулах асуудлаар аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Эх сурвалж: Дундговь аймаг дахь ТАГ

Төрийн өмчит байгууллагуудын хувьд аймгийн Авто тээврийн газраас ирүүлсэн мэдээллээр ашиглагдаж байгаа бүх төрлийн авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг сольж хуулийн хэрэгжилтийг хангасан байна.

1.4 Албан тасалгаа - 7 дугаар зүйл

Байгууллагын хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөөнд захиргааны зориулалттай барилга шинээр барихаар тусгасан эсэхийг тулган шалгахад зөрчил илрээгүй.

1.5 Дүрэмт хувцас - 8 дугаар зүйл



Санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагуудын мөнгөн хөрөнгийн зарлагын журналаас дүрэмт хувцас, бусад хувцас хэрэглэл худалдан авсан эсэхийг шалгахад нийт 10.9 сая төгрөгөөр ажилтнуудад бэлтгэлийн хувцас худалдан авсан зөрчил илэрсэн. Тус зөрчлийн 1.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 9.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүллээ.

1.6 Албан томилолт - 9 дүгээр зүйл

Албан томилолтоор ажиллуулсан байгууллагаас томилолтын зардал гаргасан эсэхийг шалгаж, бусад байгууллагаас давхардуулан зардал олгосон эсэхийг шалгахад зөрчил илрээгүй байна.

1.7 Цалин хөлс, нэмэгдэл - 10 дугаар зүйл

“Дундговь-Ус” ОНӨААТҮГ -ын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар ашигт ажиллагааны түвшин алдагдалтай, татварын байгууллагад өглөгтэй байхад ИТХ-ын шийдвэргүйгээр ТУЗ-ын гишүүдэд 8.4 сая төгрөгийн урамшуулал олгосон зөрчил илэрч албан шаардлага хүргүүлсэн байна.

2023 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 08, 48 дугаар тогтоолуудаар Дундговь-Ус, Мандалын гэгээ ОНӨААТҮГ-уудын цалин хөлсний жишиг хэмжээг тогтоож 2024 онд мөрдөж ажилласан боловч 2025 онд шинэчлэн тогтоогүй, ОНӨААТҮГ-ууд өмнө нь тогтоосон жишиг цалин хөлсийг баримталж байна.

Харин Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын хувьд үйл ажиллагаа явуулаагүй тул АИТХ-аас тогтоол гаргаагүй байна.

Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв ОНӨААТҮГ нь 2023 онд шинээр байгуулагдаж, ТУЗ-ийн тогтоолоор бүтэц орон тоо, цалинг тогтоосон байна.

Иймээс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10.1⁹-т заасан ОНӨААТҮГ-уудын цалин хөлсний жишиг хэмжээг үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан тогтоож ажиллах шаардлагатай байна.

1.8 Нэг удаагийн тэтгэмж-11 дүгээр зүйл

Тэтгэвэрт гаргахад олгосон нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг бусад тэтгэмжтэй давхардуулан олгосон эсэхийг тушаал шийдвэр, мөнгөн хөрөнгийн зарцуулалт, анхан шатны баримт руу хөөн шалгахад зөрчил илрээгүй.

1.9 Бусад хангамж- 12 дугаар зүйл



Тус хуулийн 3.1-д заасан этгээд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглосон. Үүнд:

12.1.1 гар утасны зардал;

⁹ Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

12.1.2 ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал;

12.1.3.хэвлэлийн захиалгын төлбөр;

12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад.

Тус хуулийн 12.1.1, 12.1.3 -т заасныг зөрчиж 1.1 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрч төлбөрийн акт тогтоосон байна. Тухайлбал:

- Хоршоо хөгжүүлэх сангаас төсөл сонгон шалгаруулах хороо болон хяналтын зөвлөлийн гишүүдэд гар утасны нэгжид 0.5 сая төгрөгийг хяналтын зардлаас зарцуулсан.
- Бичиг хэргийг зардлаас сонин хэвлэлийн үнэ төлж 0.6 сая төгрөгийг зориулалт бусаар хэмнэлтгүй зарцуулсан.

1.2. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД ХЭМНЭЛТИЙН БУСАД АРГА ХЭМЖЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ЗААЛТЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ 537.7 САЯ ТӨГРӨГИЙГ ХЭМНЭЛТГҮЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

 Төсөв захирагчдын 2022-2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой 537.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнээс 85.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэх 55 төлбөрийн акт тогтоож, 435.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 52 албан шаардлага, 16.0 сая төгрөгийн 9 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

Хүснэгт №3: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасныг зөрчсөн асуудал

№	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалт	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТХТХ 15.1.3. ¹⁰	44	63.4	38	112.6	8	16.0	90	192.1
2	ТХТХ 15.1.5. ¹¹	5	9	2	4.5	0	0	7	13.5
3	ТХТХ 15.1.6. ¹²	2	6.7		0		0	2	6.7
4	ТХТХ 15.1.7. ¹³	1	1.7		0		0	1	1.7
5	ТХТХ 15.2.2. ¹⁴		0		0	1	0	1	-
6	ТХТХ 15.2.3. ¹⁵	1	0.2	5	38.5		0	6	38.8
7	ТХТХ 15.2.4. ¹⁶		0	2	19.2		0	2	19.2
8	ТХТХ 15.2.6. ¹⁷	2	4.7	5	261		0	7	265.6
Нийт дүн		55	85.8	52	435.9	9	16.0	116	537.7

Эх сурвалж: Дундговь аймаг дахь ТАГ

¹⁰ хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;

¹¹ төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;

¹² нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;

¹³ байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах.

¹⁴ нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах;


¹⁵ сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

¹⁶ цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх;

¹⁷ байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.

Нийт зөрчлийн **18.8** хувь буюу **101.0** сая төгрөгийн зөрчил нь 2022 онд, **2.0** хувь буюу **11.0** сая төгрөгийн зөрчил 2023 онд, **79.2** хувь буюу **425.7** сая төгрөгийн зөрчил нь 2024 онд тус тус илэрсэн байна.

График № 1




Зөрчлийн дүн 2024 онд 2022 оноос 60.4 хувь буюу 324.7 сая төгрөгөөр өссөн байна. Өсөлтийн дийлэнх хувийг санхүүгийн албан хаагчдын ажлыг дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 145.9 сая төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон зөрчил эзэлж байна.

Хуулийн 15 дугаар зүйлийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрлийг агуулгаар нь авч үзвэл:

- Байгууллагын удирдлага, нягтлан бодогч, няравт санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэгдсэн үндэслэлээр балансын урамшуулал давхардуулан олгосон.
- Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтанд орон нутгийн нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал олгосон.
- Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад урамшуулал олгосон.
- ОНХС-ийн хөрөнгийг шагнал урамшууллын зардалд зарцуулсан.
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас ажилчдад биеийн тамирын хувцас худалдан авсан.
- Хөдөлмөрийн хүндэт медаль, аймгийн хүндэт тэмдэг, аймгийн Засаг даргын жуух авсан албан хаагчдад мөнгөн шагналыг давхардуулан олгосон.
- Төсвийн хөрөнгөөр бэлэг, дурсгалын зүйл бэлтгэж, хүндэтгэлийн үйл ажиллагаанд зарцуулсан
- Шаардлагагүйгээр бараа материал нөөцлөх зорилгоор төсвөөс мөнгө шилжүүлэн бараа материал, авлага дансанд бүртгээгүй.
- Төсвийн хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авсан.
- Сумын ИТХ-ын албан хаагчийг гадаад туршилага судлах арга хэмжээнд хамруулж төсвөөс байр, хоол, унааны зардлыг олгосон.
- Орон тоо, цалингийн сан батлагдаагүй ажлыг хавсруулан гүйцэтгүүлж, ажил хавсарсны нэмэгдэл олгосон

График № 2



Нийт илэрсэн зөрчлийн 49.4 хувь нь хуулийн 15.2.6 буюу байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгоогүйтэй, 35.7 хувь нь хуулийн 15.1.3 буюу төрийн албан хаагчдад хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгосон зөрчил байна. Мөн хуулийн 15.2.3 буюу сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэхтэй холбоотой зөрчил 7.2 хувийг тус тус эзэлж байна.

Хуулийн 15 дугаар зүйлийн хэрэгжилттэй холбоотой зөрчил нь нийт зөрчлийн дийлэнх буюу 41.6 хувийг эзэлж, ялангуяа цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох, хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохтой холбоотой зөрчил өндөр байгаа нь төсвийн зардал хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулагдах эрсдэлийг бий болгож байна.

Иймд ТЕЗ-аас хуулийн бусад арга хэмжээтэй холбоотой заалтыг хэрэгжилт хангалтгүй байгаа байдалд дүгнэлт хийж хэрэгжилтийг хангуулан ажиллахад анхаарах шаардлагатай байна.

2.3 Бүлэг Б. Аудитын дүн:

Б. Гол асуулт / аудитын дэд зорилт 2: Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан уу ?

Хариулт: Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмын хэрэгжилт хангалтгүй байна.

2.1 ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗУРАГ ТӨСӨВГҮЙ 166 ТАХ, ИРГЭДИЙН САНАЛ АВААГҮЙ 38 ТАХ-Г БАТАЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаарын зүйлийн хэрэгжилтийг жил бүр “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийж буй гүйцэтгэлийн аудитаар горим хэрэгжүүлэн шалгаж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын хувьд санхүүгийн тайлангийн аудит болон тусгайлан хийж буй гүйцэтгэлийн аудитын явцад горим сорил хэрэгжүүлэн шалгасан байна. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн хөрөнгөөр 2022-2024 онд нийт 227 хөрөнгө оруулалт, ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулж 4,876.5 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

Хүснэгт № 4: Зохион байгуулсан худалдан авах ажиллагаа, хэмнэлт /сая төгрөгөөр/

№	Хөрөнгө оруулалтын дансны нэр	Зохион байгуулсан худалдан авах ажиллагаа, хэмнэлт /сая төгрөгөөр/							
		2022 он		2023 он		2024 он		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ОНХО	48	153.4	36	261.1	56	542.6	140	957.2
2	УТХО	7	1,759.3			13.0	1,508.0	20	3,267.3
3	ОНХС	19	82.2	31	223.7	17.0	346.2	67	652.0
	Нийт	74	1,994.9	67.0	484.8	86	2,396.8	227	4,876.5

Эх сурвалж: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

Тус хэмнэлтийг ОНХО болон ОНХС-ийн хувьд дараагийн төсвийн жилийн эх үүсвэрт тусган аймгийн ИТХ-аар баталсны дагуу зарцуулж байна. Харин улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайд Сангийн яамнаас хөрөнгө оруулалт ТАХ-ний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгагдсан дүнгээр санхүүжилтийг нь олгож байгаа учир орон нутагт хэмнэлтийн зарцуулалтыг шалгах боломжгүй байна.

2022-2024 онд УТХО болон ОНХС-ийн хөрөнгөөр холбогдох хууль, журам, зааврын дагуу ТЭЗҮ, төсвийн тооцоолол, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгаагүй, магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг, төсөвгүй 166 ТАХ-г санхүүжүүлэхээр 26,609.3 сая төгрөгийг төлөвлөж, баталсан байна. Мөн ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн саналаар дэмжигдээгүй, санал авч эрэмбэлэгдээгүй 38 ТАХ-нд 1,160.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Дээрх зөрчлүүд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3¹⁸-т, 13.5¹⁹-д заалттай зөрчсөн тул зөрчлийг арилгуулахаар ТЕЗ нарт тухай бүр албан шаардлага хүргүүлж, биелэлтийг нь хангуулж ажилласан байна.

Хүснэгтээс харахад 2024 онд илэрсэн зураг төсөвгүй хөрөнгө оруулалтыг баталж хэрэгжүүлсэн зөрчил өмнөх оноос 16,560.2 сая төгрөгөөр өссөн байхад ОНХС-ийн хөрөнгийг иргэдийн саналаар дэмжигдээгүй хөрөнгө оруулалт ТАХ-нд зарцуулсан зөрчил өмнөх оноос 658.7 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Зураг төсөвгүй хөрөнгө оруулалтыг баталсан зөрчлийн өсөлт нь УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний өсөлтөөс шалтгаалсан байна.

¹⁸ техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.

¹⁹ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

Хүснэгт № 5: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасныг зөрчсөн асуудал

Зураг төсөвгүй хөрөнгө оруулалт ТАХ /сая төгрөгөөр/									
№	Хөрөнгө оруулалтын дансны нэр	2022 он		2023 он		2024 он		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ОНХО							-	-
2	УТХО	1	1,940.5	1	475.0	2	19,127.6	4	21,543.1
3	ОНХС	7	436.0	87	3,361.30	68	1,268.9	162	5,066.2
	Нийт	8	2,376.5	88.0	3,836.3	70	20,396.5	166	26,609.3
Иргэдийн саналаар дэмжигдээгүй хөрөнгө оруулалт ТАХ /сая төгрөгөөр/									
1	ОНХС	4	170.5	28	824.5	6	165.8	38	1,160.8

Эх сурвалж: Дундговь аймаг дахь ТАГ

Энэ нь хөрөнгө оруулалт ТАХ-ний төлөвлөлт гүйцэтгэлд хариуцсан байгууллага, албан тушаалтны ажлын хариуцлага, аймаг сумын Засаг дарга, ИТХ-ын төлөөлөгч нар хяналтын байгууллагаас хууль тогтоомжийн хүрээнд тавьж буй шаардлагыг хүлээн авахгүй эрх мэдлээ хэтрүүлэн, хууль бус шийдвэр гаргаж байгаатай холбоотой байна.

Мөн ТАХ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй байх, улмаар өөр хэрэгцээ шаардлагатай, ач холбогдолтой хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх боломжийг хааж төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх эрсдэлийг бий болгож байна.

2.2 ЦАХИМ ДЭЛГҮҮРЭЭС БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХАД ОРЧИН НӨХЦӨЛ ХАНГАЛТТАЙ БҮРДЭЭГҮЙ УЧРААС ХУДАЛДАН АВАГЧ БАЙГУУЛЛАГУУДААС ХУУЛИЙН ТУС ЗААЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ ҮҮССЭН БАЙНА.



Төсөв захирагч нарын 2022-2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй этгээдээс тавилга, тоног төхөөрөмж худалдан авсан 408.6 сая төгрөгийн 28 зөрчлийг илрүүлж 27 албан шаардлага 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн байна. 2023 онд ТЕЗ-д цахим дэлгүүрийн худалдан авалттай холбоотой мэдээллийг төсвийн шууд захирагч нарт таниулах сургалт, сурталчилгааг хийж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн боловч 2024 онд зөрчлийн дүн өмнөх оноос 186.2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлтэй өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Иймд ТЕЗ-ын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн гүйцэтгэлийн аудитаар зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлжээ. Хүснэгт № 7

Хүснэгт № 6: Цахим худалдан авалттай холбоотой зөрчил

Албан шаардлага /сая.төг/				Зөвлөмж /сая.төг/		Нийт	
2023		2024		2024			
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
6	111.2	21	297.4	1	-	28	408.6

Эх сурвалж: Дундговь аймаг дахь ТАГ

Энэ нь төсөв захирагч, санхүүгийн ажилтнууд цахим дэлгүүрийн талаарх ойлголт дутмаг, хэрхэн яаж бараа, үйлчилгээг худалдан авахаа мэддэггүй, зарим бараа нь бусад дэлгүүрээс үнэтэй гэсэн шалтгаанаар худалдан авалт хийгээгүйтэй холбоотой байна. Нөгөө талаар цахим дэлгүүрт байршсан бараа бүтээгдэхүүн нь зах зээл дээрх бараа бүтээгдэхүүний бодит үнээс зөрүүтэй буюу үнэтэй, сонголт муу худалдан авагчийн тавьсан шаардлагад нийцэхгүй байгаа нь цахим дэлгүүрээс бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахад орчин нөхцөл хангалттай хэмжээнд бүрдээгүй нэг шалтгаан болж байна.

Иймд цахим дэлгүүрийн худалдан авалттай холбоотой мэдээлэл, сургалтыг орон нутгийн төсөв захирагчдад хийж, цахим дэлгүүрт бүртгүүлэн, хууль, журмын хэрэгжилтийг хангуулан ажиллахад анхаарах шаардлагатай байна.

Мөн цахим дэлгүүрийн бараа, бүтээгдэхүүний нэр төрөлд хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баяжилт хийх, зах зээл дээрх бараа, бүтээгдэхүүний үнэд судалгаа хийх замаар үнийн бодлогод өөрчлөлт оруулах асуудлаар Төрийн худалдан авах ажиллагааны газарт уламжлахаар шийдвэрлэлээ.

2.3 Бүлэг В. Аудитын дүн:

В. Гол асуулт / аудитын дэд зорилт 3 : ЗГ болон бусад төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан уу

Хариулт: ТЕЗ болон түүний дотоод аудит Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, түүнд тавих хяналт хангалтгүй байна.

3.1 ТЕЗ БОЛОН ОНӨААТҮГ-УУДЫН УДИРДЛАГААС ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллагыг тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1²⁰-дэх заалтаар баталгаажуулсан байна. Төрийн аудитын газраас МУЕА-ын 2022 оны А/89 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг мөрдөж, улс, орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээд, орон нутгийн тусгай сангийн 2022-2024 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад горим, сорилыг хэрэгжүүлж, улмаар **1,289.4** сая төгрөгийн зөрчилд акт, албан шаардлага, зөвлөмж өгч, биелэлтийг хангуулсан.

Аудитын явцад аймгийн ТЕЗ-д тус хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний тайланг ирүүлэхээр албан бичиг хүргүүлсэн боловч тусгайлан хийсэн тайлан байхгүй гэсэн тайлбарыг өгч 2025.05.05-ны өдрийн 01/632 дугаар албан бичгээр хийсэн ажлуудын талаар товч мэдээлэл өгсөн. Үүнд:

- Хууль хэрэгжснээс хойш урсгал болон хөрөнгийн зардлаас 10,296.6 сая төгрөгийг хэмнэсэн;
- Байгууллагуудын уралдаан тэмцээн зохион байгуулах, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг бууруулах, цалин хөлсийг үр ашигтай нь уялдуулан олгох, сургалт семинар, хурал, зөвлөгөөнүүдийг цахимаар болон зориулалтын танхимд зохион байгуулж, албан бичгийг хялбаршуулан тоон гарын үсэг ашиглан цахимаар илгээх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн;
- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны үр дүнд 3,212.7 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож, дараа онд шилжүүлсэн;
- 18 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлж, аймгийн ИТХ-ын тогтоолоор 2 тээврийн хэрэгслийг хэрэгцээт байгууллагад нь шилжүүлж, 16 тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулсан;
- 85 тендер шалгаруулалтыг цахимаар зарлаж, 63 тендер шалгаруулалтад гэрээ байгуулсан.

Аймгийн ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, хяналт, шалгалтын дүнг ирүүлээгүй, хуулийн хэрэгжилт үр дүнг тооцож ажиллаагүй байна. Мөн ОНӨААТҮГ-уудын удирдлагаас Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах ажлыг хэрэгжүүлээгүй байна. Дээрх зөрчлүүд нь хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1²¹ 19.2²² дахь заалтыг зөрчиж байгаа тул орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ТЕЗ болон ОНӨААТҮГ-уудын удирдах албан тушаалтнуудад хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах асуудлаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

²⁰ Энэ хуулийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана.

²¹ Энэ хуулийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана.

²² Төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан энэ хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах ажлыг хэрэгжүүлнэ.

3.2 ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ТӨСӨВТ 15,173.1 САЯ ТӨГРӨГИЙН ХЭМНЭЛТИЙГ БИЙ БОЛГОСОН Ч ЗӨРЧИЛ ӨМНӨХ ЖИЛЭЭС НЭМЭГДСЭН БАЙНА



Дундговь аймгийн ТЕЗ-аас Төрийн хэмнэлтийн тухай хууль хүчин төгөлдөр болж хэрэгжиж эхэлснээс хойш хуулийн хэрэгжилтийг хангуулах асуудлаар харьяа бүх шатны төсөв захирагчдыг удирдлага мэдээллээр хангаж, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын санхүүжилтийн зарцуулалтад хэмнэлтийн горимыг мөрдөж 2022-2024 онд үйл ажиллагааны зардал болон хөрөнгийн зардлаас 10,296.6 сая, төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны хэмнэлтээр 4,876.5 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна. Гэсэн хэдий ч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил 2024 онд **789.9** сая төгрөг болж 2022 оноос **487.0** сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байгаа тул Төрийн хэмнэлтийг хангуулах асуудлаар дахин тодорхой бодитой арга хэмжээ авч хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллах шаардлагатай байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр төсөвт байгууллагын төсвийн зардлыг хязгаарлаж, илүү оновчтой, үр ашигтай зарцуулалт хийх боломж бүрдсэн хэдий ч зарим байгууллагад хэрэгжилт жигд бус, хэмнэлт, үр ашиг хангалтгүй байна.

3.3 ЗАРИМ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛГҮЙ, ЗӨРЧИЛ ДАВТАГДАН ГАРЧ БАЙНА.



Төрийн аудитын газраас МҮЕА-ын 2021 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд аудит хийх аргачлал”-ын дагуу төсөв захирагчдын 2022-2024 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад давхардсан тоогоор **614** байгууллагыг хамруулж **86** байгууллагад албан шаардлага, **70** байгууллагад зөвлөмж өгч, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан 12 байгууллагын 15 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлж биелэлтийг хангуулсан байна. Дээрх зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²³- заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байгааг харуулж байна.

Зөрчлийн дийлэнх нь цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээших орлого зарлагын гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан тушаал шийдвэр, 5 сая төгрөгөөс дээших худалдан авалтыг мэдээлээгүй зэрэг зөрчлүүд эзэлж байгаа бөгөөд 2024 оны байдлаар зөрчлийн тоо 2022 оноос 26 - аар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт №7: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил

№	Огноо	Зөрчлийн төрөл /тоогоор/			
		Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулсан	Нийт
1	2022	36	31		67
2	2023	26	27	7	60
3	2024	24	12	5	41
Нийт дүн		86	70	12	168

Гэсэн хэдий зөрчил бүрэн арилахгүй, зарим албан тушаалтан зөрчлийг давтан гаргасаар байна. Энэ нь дотоод хяналт муу, хариуцлагын тогтолцоо сул байгааг илтгэж байна. Иймд мэдээллийн ил тод байдалд хяналт тогтмол тавьж, шилэн дансны цахим

хуудсыг тогтмол хянаж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

²³ Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Үүнд:

1. Хуулийн 5-12 дугаар заалттай холбоотой нийт **537.7** сая төгрөгийн зөрчил илэрч, **85.8** сая төгрөгийн төлбөрийн акт, **435.9** сая төгрөгийн албан шаардлага, **16.0** сая төгрөгийн зөвлөмжийг хүргүүлжээ.
2. Төрийн байгууллагууд хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, үр дүн хангалтгүйгээс нийт **537.7** сая төгрөгийг хэмнэлтгүй зарцуулсан байна.
3. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зураг төсөвгүй 166 ТАХ, иргэдийн санал аваагүй 38 ТАХ-г баталж хэрэгжүүлсэн байна.
4. Цахим дэлгүүрээс бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахад орчин нөхцөл хангалттай бүрдээгүй учраас худалдан авагч байгууллагуудаас хуулийн тус заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүссэн байна.
5. ТЕЗ болон ОНӨААТҮГ-уудаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, түүнд тавих хяналт хангалтгүй байна.
6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлснээр бий болсон хэмнэлттэй, үр ашигтай байдлыг тодорхойлох боломжгүй байна.
7. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтагдан гарсаар байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд дүгнэлт хийж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, хяналт тавих асуудлаар тодорхой ажил зохион байгуулж, санхүүгийн сахилга батыг сайжруулж, ил тод байдлыг хангаж ажиллах;
2. Орон нутгийн өмчит байгууллагын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа шалтгаангүйгээр тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй авто тээврийн хэрэгслийн дугаарыг шинэчилж хуулийн хэрэгжилтийг хангуулж, хяналтыг сайжруулах;

ОНӨААТҮГ-ын захирлуудад:

1. Төсвийн жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшний мэдээллийг харьяа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж байгууллагын гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг тогтоолгон мөрдөж ажиллах;
2. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах ажлыг хэрэгжүүлж төсвийг хэмнэлттэй үр, ашигтай зарцуулж байгууллагын ашигт ажиллагааны түвшнийг нэмэгдүүлэн ажиллах.

Анхаарах асуудал: Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь аудитын үр дүнд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлэхээр заасан байдаг тул хуулийн хугацаанд төлөвлөгөөг ирүүлж, хэрэгжилтийг нь хангаж ажиллахыг хүсье.



ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮЛЭХ АНАЛ

ҮАГ-аар дамжуулан Төрийн худалдан авах ажиллагааны газарт дараах зөвлөмжийг хүргүүлэх саналыг уламжилж байна. Үүнд:

Үндэслэл 1:

Төсөв байгууллагуудад цахим худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулаагүй, цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй этгээдээс бараа, бүтээгдэхүүн худалдан авч хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. дэх заалтыг хэрэгжүүлээгүй, 2024 онд зөрчлийн дүн өмнөх оноос 186.2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахгүй байна.

Энэ нь төсөв захирагч, санхүүгийн ажилтнууд цахим дэлгүүрийн талаарх ойлголт дутмаг, хэрхэн яаж бараа, үйлчилгээг худалдан авахаа мэддэггүй, зарим бараа нь бусад дэлгүүрээс үнэтэй гэсэн шалтгаанаар худалдан авалт хийгээгүйтэй холбоотой байна. Мөн цахим дэлгүүрт байршсан бараа бүтээгдэхүүн нь зах зээл дээрх бараа бүтээгдэхүүний бодит үнээс зөрүүтэй буюу үнэтэй, худалдан авагчийн тавьсан шаардлагад нийцэхгүй байгаа нь нэг шалтгаан болж байна. /Энэ талаар аудитын тайлангийн 13-14 дүгээр хуудсанд дэлгэрэнгүй оруулсан./

Санал 1:

Цахим дэлгүүрийн бараа, бүтээгдэхүүний нэр төрөлд хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баяжилт хийх, зах зээл дээрх бараа, бүтээгдэхүүний үнэд судалгаа хийх замаар үнийн бодлогод өөрчлөлт оруулах саналыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт уламжлах.

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сум, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn ОН